



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/392

Мандалговь

“Дэмжих баг” байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг хянах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн “Дэмжих баг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд хамгааллын мэргэжилтэн
Гишүүд:	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Боловсрол, соёл урлагийн газрын Гадаад хэл, нийгмийн ухааны мэргэжилтэн

Хоёр. Сумдын хамтарсан багт арга зүйн дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаанд нь тасралтгүй хяналт тавьж, хагас жил тутамд тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819110